

Хамбургийн программын хэсгээс

Германы социалист ардчилсан намын үндсэн зарчмын программ

Хамбургт 2007 оны арван сарын 28-нд болсон ГСАН-ын Холбооны их хурлаас батлав.

Бидний үндсэн үнэ цэнэ ба гол итгэл үнэмшил

Социалист ардчилсан нам германы хамгийн анхны нам бөгөөд үргэлж олон улсын эрх чөлөөний хөдөлгөөний нэг хэсэг нь байсан билээ. Анх байгуулагдахдаа хоёр талтай байлаа: Тэр нь дээдсийн эрх ашгийг хамгаалдаг төрийн эсрэг тэмцэх зорилготой ажилчдын тэгш эрхийн төлөө болон ардчиллын төлөө хөдөлгөөнүүд байсан ба нөгөө талаар тус нам германд францын хувьсгал, 1848 оны хувьсгалын үзэл санааг үргэлжлүүлсэн юм. Германы ардчиллын түүхийг социалист ардчиллын түүхээс салгаж болохгүй. Тэрээр эрх чөлөөтэй байх эрх, ардчилал болон эмэгтэйчүүдийн сонгох эрхийг тэмцлээрээ олж аван аливаа диктатурыг эсэргүүцсэн юм. Мөн тэрээр национал социализмын аюулыг эртээс таньж, райхстагд бүрэн эрхийн хуулийн эсрэг зогссон. Олон социал демократчууд эсэргүүцэл үзүүлсний улмаасаа национал социализмын террорд өртөгдөн хохирсон. Сүүлд нь эрх чөлөөний төлөө эрмэлзлэл тэднийг коммунистуудаас салахад зайлшгүй хүргэв. БНАГУ-д социалист ардчиллыг дахин сэргээсэн нь эрх чөлөөний дуудлага дохио болсон билээ.

Социалист ардчилсан нам үүсэхдээ ажилчны хөдөлгөөний нэг хэсэг байлаа. Тэрээр ажиллах эрхийг тэмцэн олсон ба нийгэмт төрийг байгуулан үйлдвэрчний эвлэлтэй хамтран, ад үзэгдсэн пролетарчуудыг өөртөө итгэх итгэлтэй иргэд болгон өөрчилсөн юм.

Бусад намуудтай харьцуулахад социалист ардчилсан нам үргэлж олон улсын болон европын чиглэлийг барьдаг байсан. Тиймээс ч бид 1925 онд ГСАН-ын Хайделбергийн программд заасан, тэр үедээ мөрөөдөл байсан нэгдсэн европын төслөө үргэлжүүлэн ажиллаж, одоо дуусгах боломжтой боллоо. Хэдийгээр олон арван дайны эсрэг шийдвэртэй тэмцэгчид социалист ардчилсан намыг эх нутгаа гэж үзэж байсан авч уг нам өөрөө хэзээ ч дайныг эсэргүүцэгч нам байгаагүй юм. Гэвч тэрээр үндэсний дээрэнгүй үзэл, милитаризмыг зөвшөөрдөггүй байв. Засгийн газрын хариуцлагыг авсан үедээ тэрээр энх тайвны төлөө ажилласан. Бид дайн дажин, дарлал зовлон, хүчээр эзэмдэлтийг ард түмэндээ хэзээ ч авчраагүйдээ бардам байдаг.

Социалист ардчилсан нам анхнаасаа ардчилсан нам байсан. Тэрээр манай орны улс төрийн соёлд шийдвэрлэх роль гүйцэтгэсэн юм. Намд төрөл бүрийн давхаргаас гаралтай, янз бүрийн шашны ба ертөнцийг үзэх үзэлтэй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ажилладаг. Уг нам нь 1959 оны Годесбергийн программаас хойш жүүдийн ба христийн шашин, хүнлэг ёс ба соён гэгээрүүлэлт, марксист нийгмийн анализ ба ажилчны хөдөлгөөний туршлага дээр тулгуурласнаараа зүүнийг баримталсан ард түмний нам мөн. Зүүнийг баримталсан ард түмний нам эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ба нийгмийн шинэ хөдөлгөөнүүдийн ачаар чухал түлхэцээ олж байдаг.

Цаг үе бүхэн нийгэм, улс төрийн асуудлуудаас өөрийн хариугаа шаарддагийг бид мэднэ. Нийгмийн хөгжилд өгөх цаг үеэ олсон хариуг олох тэмцлийн явцад бид саналаа чөлөөтэй гаргаж, маргалдах замд орсон. Бид хувийн үзэл бодол, итгэл үнэмшлийг сайшаадаг, хүндэлдэг. Тэднийг намын шийдвэрт захируулж болохгүй. Биднийг нэгтгэж байгаа зүйл бол нийгэм байгуулж болдог, капиталист даяарчлалын сохор үйл ажиллагаанд бууж өгөхгүй гэсэн үзэл билээ. Биднийг нэгтгэж байгаа бас нэг зүйл бол социалист ардчилсан улс төр нь үйлдвэрчний эвлэл, энх тайвны, эмэгтэйчүүдийн, байгаль орчны, хүний эрхийн, нэг дэлхий ертөнцийн төлөө болон даяарчлалд шүүмжлэлтэй ханддаг хөдөлгөөнүүдэд оролцдог хүмүүсийн ардчилсан идэвх санаачлагатай холбоотой байж амжилтанд хүрдэг түүхэн туршлага маань юм. ГСАН цаашид ч энэ хөдөлгөөнүүдтэй холбоотой байх болно.

Хүний тухай бидний ойлголт

Хүн бүрийн адил тэгш нэр хүнд манай бодлогын эх үүсвэр, гол зорилт билээ. Хүмүүс өөр өөр боломжийг өөртөө тээж явдаг. Тэднийг сайн, муу гэж алиугаар нь ч шууд хувааж болохгүй. Тэд оюун ухаантай, юм сурах чадвартай. Тиймээс ардчилал боломжтой. Тэд алдаа хийж болно, алдаж эндүүрэн хүнлэг бус байдалд эргэн орж болно. Тиймээс ч ардчилал хэрэгтэй. Хүн бүр өөрийн амьдралын өмнө хариуцлага хүлээдэг. Хэн ч түүнийг өмнөөс нь үүрэхгүй. Хүнийг төрийн зүгээс ч, эдийн засгийн талаас ч ямарваа нэгэн зорилгын зэвсэг болгон гутааж болохгүй. Бид хүнийг захирах ямарваа улс төрийн төгс хүчин байхыг эсэргүүцнэ. Хэрэв улс төр аз жаргал, есөн хүслийн биелэлийг амлаад эхлэх юм бол тэр өөрөө бүрэн дарангуйлах засаглалд хальтран орох аюулд учирна гэсэн үг.

Ардчилал бол хүний өөрийн хариуцлагад тохирон, улс төрийн хил хязгаарыг хэмжиж байдаг улс төрийн ганцхан зохицуулалт билээ. Хүний ба иргэний эрх хоёр улс төр, төрийн аппаратуудад хил хязгаар тогтоодог. Түүнгүйгээр ардчилал байх боломж үгүй. Хүн өөрөө зөвхөн эрх үүргийнхээ хамтаар нэгэн хувь хүн байхаар зогсохгүй, холбоо тогтоодог, түүнийг тогтооход бэлэн нийгмийн нэг хэсэг мөн. Ардчилал нийгмийн ялгаатай давхаргуудын, үеэс үеийн, гарал үүслүүдийн хоорондын эвсэг байдлыг үүсгэн, тус холбоо тогтооход бэлэн байдлыг дэмждэг.

„Нэр хүнд ба эрх нь чөлөөтэй, адил тэгш“ гэж хүний эрхийн ерөнхий тайлбарт орсон ба хүн өөрийн амьдралаа нийгэм дотор бусадтай хамтран шийдэх боломжтой байх ёстой гэж заасан. Бидний зорилго бол хүн бүр өөрийгөө чөлөөтэй хөгжүүлж, бусдын нэр хүнд, эрх чөлөөнд халдалгүйгээр, чөлөөтэй, эрх тэгш нийгэмд амьдрах явдал. Хавчин дарангуйлахын аливаа хэлбэрийг бид эсэргүүцнэ. Хүний нэр хүнд түүний чадвар, эдийн засгийн ашиг тусаас хамаарахгүй. Тийм учраас нийгэм хүн тахир дутуу эсвэл нас өндөр болох, амьдралаа эхлэх, төгсөх үед нь түүний нэр хүндийг онцгой хамгаалах үүрэгтэй.

Бидний гол үнэ цэнэ

„Эрх чөлөө, тэгш эрх, ах дүүсэлт“ гэсэн францын хувьсгалын үндсэн шаардлагууд европын ардчиллын гол үндэс суурь юм. Адил тэгш эрх чөлөөнд зорих зорилт одоо үед шударга ёсны мөн чанар/эрхэм жишээ болж, эрх чөлөө, тэгш эрх, эв нэгдэл чөлөөт ардчилсан социализмын гол үнэ цэнэ нь болсоор ирсэн, байсаар ч байна. Энэ нь манай улс төрийн байдлыг дүгнэх хэмжүүр болж, сайн нийгмийн байгууллын хэм хэмжээ байж, социал демократуудын үйл ажлын зүг чиглэл хэвээр үлдэнэ.

Социалист ардчиллын түүхэнд дандаа эрх чөлөөний хууль эрхийн ба материаллаг нөхцлүүд, тэгш эрх, ижил тэгш оролцоо болон боломжтой амьдралын хажуугаар нийгмийн адил тэгш байдлын төлөө тэмцэх асуудлууд байсан.

Консерватив ба либерал намынхан гол үнэ цэнийг хооронд нь мөргөлдүүлэн тавих нь ховор бус: Хир их эрх чөлөө байна, тэр хирийн бага адил тэгш байдал байдаг гэх мэт. Социалист ардчиллын ойлголтоор энэ хоёр ойлголт нэгдэж нэг зүйлийг бий болгоно. Энэ хоёр ойлголт адил үнэ цэнэтэй, нэг зэрэглэлийн зүйлс. Хамгийн гол нь: Энэ хоёр бие биенээсээ хамаарч, биенээ нөхөж, тулан дэмжиж, харилцан биендээ хязгаар тавьж байдаг. Бидний гол үнэ цэнийн тухай ойлголт эрх чөлөөг зах зээлийн эрх чөлөөтэй, тэгш эрхт байдлыг хууль эрхт төр засагтай, эв нэгдлийг ядуусыг халамжлахтай хольж хутган эндүүрэхээс биднийг хамгаалдаг.

Эрх чөлөө гэдэг нь өөрөө мэдэж амьдралаа зохицуулах боломж гэсэн үг. Ямар ч хүн эрх чөлөө рүү тэмүүлдэг, түүнийг эдлэх чадвартай. Тэрээр энэ тэмүүлэлдээ хүрч амьдарч чадах эсэхийг нийгэм

шийднэ. Хүн өөрийг нь уруу дорой болгох элдэв хамаарлаас, гачлан зовлон болон айдсаас өөрийгөө чөлөөлж, чадвараа хөгжүүлэн нийгэм, улс төрд хувь нэмрээ оруулах боломжийг олох ёстой. Нийгмээс хүрэлцээтэй хамгаалалттай гэж мэдэрсэн хүн л өөрийн эрх чөлөөгөө эдэлж чадна.

Өөр хэн нэг хүний эрх чөлөөнд халдсанаар тухайн хүний эрх чөлөө дуусна. Хэн аливаа нэгэн хүнийг эрх чөлөөгүй болгоно, тэр хүн яваандаа өөрийн эрх чөлөөгөө алдана гэсэн үг.

Тэгш эрх хүний нэр хүндийн асуудалтай холбоотой. Энэ нь гарал үүсэл, хүйснээс хамааралгүйгээр, адил тэгш эрх чөлөө, амьдрах боломж хүнд олгоно гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, боловсрол, ажил, нийгмийн баталгаа, соёл ба ардчилалд ижил тэгш оролцох болон нийтийн сангаас адил тэгш хүртэх нь шударга зүйл гэсэн ойлголт юм. Нийгэмд орлого буюу хөрөнгийг тэгш бус хувааж, хүмүүст нэг нь нөгөөгөө ноёлох боломж олгон, ижил тэгш эрх чөлөөний ойлголтыг хөсөрдүүлбэл, тэр нь шударга бус явдал болж байгаа юм. Тиймээс орлого, хөрөнгө, эрх мэдлийг адил тэгш хуваахыг шударга байдал шаардаж байна. Хэрэв хуваалтын үед их хэмжээний адил тэгш бус байдал гарвал амьдрах боломжийн ижил тэгш байдал алдагдана. Тийм ч учраас нийгмийн ардчилал хэрэгтэй.

Амьдрах боломжийн ижил тэгш байдал гэдэг нь бүхнийг тэгшитгэнэ гэсэн үг биш. Харин ч тэрээр хүнийг өөрийгөө хөгжүүлэхэд тухайн хүний онцлог, чадварт тохирсон орон зайг олгоно. Хүмүүс хоорондоо ялгаатай, цаашид ч тийм байх болно. Гэхдээ төрөлхийн ялгаа, өөр өөр нийгмийн гарал хүмүүсийн нийгмийн хувь заяа болох ёсгүй. Хүний амьдралын зам анхнаасаа тогтоогдсон байж болохгүй. Бид гарал, удам, нийгэм дэх байр суурь, арьсны өнгө, хүйс, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэгээс хамаарч ямарваа хэлбэрээр эрх ямба эдлэх буюу хохирол амсах явдлын эсрэг зогсоно.

Хөдөлмөрийг үнэлэх, хүндлэх хэрэгтэй. Цалин мөнгийг хөдөлмөрийн хир хэмжээнд тааруулан олгох нь шударга явдал мөн. Дунджаас дээгүүр цалин авч байгаа буюу бусдаас илүү хөрөнгөтэй хүн нийгмийн сайн сайхны төлөө нийгэмд илүү хувь нэмэр оруулах ёстой.

Эв нэгдэл гэдэг нь харилцан нягт холбоотой, хамтын үзэл санаатай, харилцан туслалцана гэсэн ойлголт юм. Тэрээр хүмүүс бие биенийхээ төлөө байж, харилцан туслалцахад бэлэн байх байдал билээ. Тэр хүчтэй ба сул доройчуудын, үеэс үеийнхний болон ард түмнүүдийн хооронд үйлчилнэ. Эв нэгдэл өөрөө өөрчлөлтийн эрх мэдлийг бий болгодгийг ажилчны хөдөлгөөний туршлага харуулсан. Эв нэгдэл нь манай нийгмийг бүрэн бүтэн барьж байгаа их хүч бөгөөд – аяндаа үүсэх өөрийн онцлог бүхий туслалцахад бэлэн байдал, нэгдсэн дэг журамтай, зохион байгуулалттай, нийгэмт төр дахь улс төрийн баталгаатай, зохион байгуулалттай эв нэгдэл гэж бас хэлж болно.

Хүйсний тэгш байдал

Социалдемократууд эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил тэгш эрхтэй, боломжтой байхын төлөө байж, тэр нь зөвхөн цаасан дээр биш, жинхэнэ амьдрал дээр биелж байх ёстой гэж үздэг. Бид эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил тэгш, эрх чөлөөтэй, эв нэгдэлтэй зэрэгцэн оршиж болох нийгмийн төлөө тэмцдэг.

Бид эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтраад буюу салангид, гэр бүлтэй буюу гэр бүлгүйгээр амьдралаа өөрөө шийдэн сонгох боломжийг хүсэж байна.

ГСАН болон эмэгтэйчүүдийн хөдөлгөөн хоёулаа 19-р зууны эрх чөлөөний хөдөлгөөнөөс үүдэлтэй ба хүйсний тэгш байдлын төлөө үзэл санаа тэднийг холбодог. Эмэгтэйчүүдийн сонгох эрх, гэр бүл дэх адил тэгш эрх, боловсрол эзэмших адил тэгш боломж зэрэг эмэгтэйчүүдийн олон эрхийг социал демократууд тэмцэж олсон.

Өнөөгийн эмэгтэйчүүд өөртөө итгэлтэй, тэд өөрснийхөө амьдралыг өөрсдөө авч явахыг хүсэж байна. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондох харьцаа өөрчлөгдөж байна. Улам олон эрэгтэй ба эмэгтэй хүмүүс ажил ба гэр бүлийн үүргээ нөхөрсгөөр хуваахыг хүсдэг болсон.

Хууль эрхийн хувьд ижил тэгш эрхтэй байх нь жинхэнэ ижил тэгш эрх биш. Тиймээс улс төрийн шийдвэр бүхэн эмэгтэй, эрэгтэй хүмүүс, залуу охид, хөвгүүдийн амьдралд яаж нөлөөлөхийг шүүн тунгааж, шаардлагатай бол өөрчилдөг зэрэг жендерийн ерөнхий асуудлуудтай адил эмэгтэйчүүдийг шуурхай дэмжих явдал бидэнд хэрэгтэй.

Ялангуяа мэргэжил ажлын талбарт урьд байсан, хоцрогдсон адил тэгш бус байдал байсаар байна. Нийгэм, эдийн засгийн гол чухал позицуудын дийлэнхийг эрэгтэйчүүд эзэлсээр байна. Эмэгтэйчүүд адил түвшний мэргэшилтэй эрэгтэйчүүдээс олон дахин доогуур цалин авдаг.

Ажлын ерцөнд дэх олдоц болон зохицуулалтын уян хатан байдлын шаардлага зэргийг гэр бүл хүүхдүүдтэй холбоход хэцүү. Юуны түрүүн эмэгтэйчүүдэд ажлын болон гэр бүлийн дарамтууд өдөр бүрийн амьдралд нь нэмэгддэг юм. Эрэгтэй ба эмэгтэй хүмүүс ажил ба гэр бүлийн үүргээ нөхөрсгөөр хуваах нь ердийн явдал болж амжаагүй байна. Гэрийн ажлын ихэнх хэсэг эмэгтэйчүүдэд тэд ажил хийдэг ч байсан оногддог ба тэдэнд хэрэв ажил хийдэг бол ажил төрлөө эн зэрэгцүү биелүүлэхэд нь хүндрэл учруулдаг. Эмэгтэйчүүд ихэвчилж хүүхдүүд эсвэл ажлын аль нэгийг сонгох хэрэгтэй болдог.

Ажил, гэр бүлээ хамтруулан зохицуулахад бүх нутгийг хамарсан, хэрэгцээг хангасан хүүхдийг асран саатуулах байгууламжуудыг бий болгох болон хүүхдээ хүмүүжүүлэх үеийн баталгааг сайжруулах хэрэгтэй. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амьдралд ажил дээрээ өсөх, хүүхдээ хүмүүжүүлэн, ойр дотны хүнээ асрамжлах, мэргэжил дээшлүүлэх улс төрийн болон иргэний идэвх санаачлага гаргах зэрэг хоорондоо ялгаатай хэрэгцээ шаардлагууд гардаг. Тэдэнд энэ бүхэнд зориулсан цаг хэрэгтэй. Бид ажлын ертөнцийг ажлын уян хатан цагаар зохицуулж, ажил ба хувийн амьдралын тэнцүү байдлыг бий болгохыг зорьж байна. Бид эрэгтэй, эмэгтэй хүмүүс цагийг биеэ даан зохицуулах боломжийг хүсэж байна. Энэ нь сонгох эрх чөлөөг боломжтой болгох юм.

Бидэнд амьжиргааны гол эх үүсвэр болсон ажилд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн адил тэгш, шударга оролцоо хэрэгтэй. Голчилж эмэгтэйчүүдийн хийдэг ажлын хөлс бага байдаг. Гэхдээ адил хэмжээний ажилд ижил цалин олгох ёстой. Бид ажлыг зөвхөн эмэгтэй буюу эрэгтэй хүний ажил гэсэн ялгааг арилгана. Эмэгтэйчүүд удирдах ажилд очих, захиргаа, шинжлэх ухааны салбар, судалгаанд ажиллах болон хянах зөвлөлд оролцохыг хуулиар зохицуулах шаардлагатай.

Татварын хуулийг бид эмэгтэйчүүдэд саад болохгүй, ажлын биеэ даасан байдалд нь тотгор учруулахгүй байхаар болгоно.

Хэрэв бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн адил тэгш байдлыг хүсэж байгаа бол бид амьдралын бүх хүрээг өөрчлөх хэрэгтэй: Хэрэв хүнлэг нийгэм байгуулья гэвэл эршүүд байдлаа орхих хэрэгтэй.

Хүн бүрийг сайн ажилтай болгоё

Эрэгтэй, эмэгтэй аль ч хүн ажил хийх эрхтэй. Ажил нь нийгмийн амьдралд оролцох оролцооны гол түлхүүр билээ. Ажил хүнд амьдрах утга учир, нэр хүнд авчирдаг. Ажил нь нийгэмд гадуурхагдалгүй, өөрөө шийдэж зохицуулан амьдрах амьдралын боломжийг бий болгоно. Ажилгүйдэл хэдийгээр ихэнх тохиолдолд өөрийн буруугаас болдоггүй ч хүний нэр хүндийг гутааж, орчноос таслан, өвчтэй ч болгож болно.

Сайн хийсэн ажил бүхэн хүндэтгэл хүлээх учиртай боловч ажил бүхэн сайн ажил байддаггүй. Ажил хүний дайтай амьдрах амьдралын нэг хэсэг юм. Тэгэхдээ ажил хүний ёсны хэм хэмжээнд байх ёстой.

Бид шударгаар үнэлэгдсэн, нийгмийн хамгааллын системд хамрагдсан, нэр хүндтэй, өвчлүүлдэггүй, эзэмшсэн мэрэгжлээ ашиглаж, түүнийгээ улам боловсруулах боломж өгдөг, ардчилсан оролцоог баталгаажуулсан, ажил, гэр бүлээ хослуулах боломж олгодог ажлыг хүсэж байна. Сайн ажил гэдэг ойлголтын дотор хувиар эрхлэх ажил бас багтана. Мөн түүнчлэн сайн дурын, нийгмийн чухал ажлыг ч дэмжин хөхиүлэх хэрэгтэй.

Сайн боловсрол, хүүхдэд ээлтэй нийгэм, бат бэх гэр бүлүүд

Социалист ардчилсан намын эх үүсвэр болсон 19-р зууны ажилчны хөдөлгөөний анхны зорилтууд нь нийгмийн оролцоо болон боловсрол байлаа. „Бидний хүүхдүүдийн амьдрал биднийхээс дээр байх ёстой“ гэсэн уриалга илүү сайн ирээдүйн төлөө тэмцсэн олон хүний тэмцлийн лоозон байв. Уг зорилтууд орчин үед тохирсон нөхцөлтэйгээр улс төрийн үйл ажиллагааны төвд тавигдах ёстой.

Бид хүн бүрийг адилхан амьдрах бололцоогоор хангахыг хүсэж байна. Адилхан амьдрах бололцоотой болохыг юуны түрүүн боловсрол болон гэр бүл шийднэ. Тиймээс бид бүх хүний боловсролыг сайжруулах, гэр бүлийг бэхжүүлэхийн төлөө ажиллана. Бидний зорилго бол хүүхдэд тааламжтай нийгмийг байгуулах явдал юм.

Боловсрол бидний хувь заяаг шийдэх орчин үеийн нийгмийн хамгийн гол асуудал билээ. Тэрээр хүмүүст өөрсдөө шийдэж зорилгоо тогтоох, хүслээ биелүүлэх боломжийг олгоно. Тэрээр бас хүнд дэлхий нийтийн хувьсал дэвшилд оролцох замыг нээдэг. Тэрээр хүнийг ардчилал, нийгмийн хариуцлагад хүргэдэг. Тэрээр хүнд ажиллах боломж өгч, оролцоог болон нийгэмд шат ахих хэтийн төлөвийг шинээр бий болгодог юм. Тэрээр ач холбогдол нь түргэн өсөж байгаа эдийн засгийн үр ашигтай хүч мөн. Бид илүү сайн мэрэгжилтэй ажиллагааны тоог эрс нэмэгдүүлэхийг хүсэж байна. Нээлттэй, нийгмийн бүх давхаргыг хамарсан, өндөр хөгжилтэй боловсролын системтэй нийгмүүд л одоогийн мэдлэгээр илэрхийлэгдэх ертөнцөд хөгжин дэгжих болно. Боловсрол нь зөвхөн мэргэжилд ашиглах төдийхний мэдлэгээр зогсохгүй. Бидэнд мэдлэг, нийгмийн мэдэл, шинэ сэргэг санаа, гоо сайхны мэдрэмж, ёс суртахууны тусгал болон үнэ цэнийн талаарх ойлголт зэрэг иж бүрэн боловсрол хэрэгтэй. Хүн амьдралд зүг чигээ олоход ганцхан мэдлэгтэй байхаар зогсохгүй, улс төрийн боловсрол эзэмшсэн, ардчилалд суралцсан байх хэрэгтэй. Боловсрол хүний хувь шинжийг бэхжүүлж, хүлцлийн чадвартай болгодог.

Мэдлэг асар хурдтай нэмэгдэж, олж авсан мэдлэг маш хурдан хоцрогдож байна. Хүмүүс урьд өмнө нь ч одоо ч амьдралынхаа төлөө бүхэл амьдралдаа суралцдаг хэвээр. Бид сурах дур хүслийг нэмэгдүүлж, шинжлэл судлалын үр дүнгийн нээлттэй байдлыг бий болгоно.

Бүхний төлөө боловсрол

Төр засаг бүх хүмүүст гарал үүслээс нь хамааралгүй сурах боломжийг өгөх үүрэгтэй. Хүн бүр үнэ төлбөр-гүйгээр ясли цэцэрлэгээс эхлэн их дээд сургууль хүртэл боловсролын замаар явах эрхтэй. Үүнийг бид хэрэгжүүлнэ. Боловсрох боломжийн дутагдлаас болж хүн боловсролоос хоцрох нь буруу явдал.

Сайн боловсролд илүү их хөрөнгө хэрэгтэй. Тэр нь хүнд гаргаж байгаа хөрөнгө оруулалт гэдэг утгаараа урьтал эрхтэй юм.

Бидэнд хоёр дахь ба гуравдагч боломжийн зуршил хэрэгтэй байна. Хэрэв хэн нэгэн хүн амьдралдаа нэг удаа мухардалд орсон бол сургуулиа төлбөргүйгээр нөхөж төгсгөн, мэргэжлийн сургуульд орох боломжтой байх ёстой.

Манай боловсролын систем анхнаасаа охид, хөвгүүдийн адил тэгш байдал болон хүйснээс болж хавчигдмал байдал үүсэхгүй байхад анхаарах хэрэгтэй. Гаднаас ирэгсэд нийгэмд багтаж ороход боловсрол шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Хамтран сурах явдал интеграцад дэмжлэг болно. Энэ асуудал тахир дутуу хүмүүст бас хамаарна.

Бүх хүмүүст боловсролыг хүргэхийн тулд бид бичиг үсгийн харанхуй байдалтай тэмцэнэ. Бид бас компьютер, интернет болон бусад хэвлэл мэдээлийн хэрэгсэлтэй хариуцлагатай, ухамсартай, шүүмжлэлтэй харьцахыг дэмжинэ.

Гэхдээ боловсрол түүнийг түгээж байгаа хүмүүсээс хамааралтай. Тэр түгээгчид хүүхдийн өдөр өнжүүлэхэд, сургуульд эсвэл их дээд сургуульд хаана ч бай, тэд нийгмээс хэдий чинээ хүндлэл, ойлголт, дэмжлэг авна, төдий чинээ амжилттай ажиллах болно. Бид тэднийг боловсролоо сайжруулж, мэргэжлээ дээшлүүлэхийг нь дэмжинэ. Бид эрэгтэй, эмэгтэй багш нарын тооны харьцааг хүүхдийн өдөр өнжүүлэхээс эхлээд их дээд сургууль хүртэл тэнцүү байх талаар анхаарах хэрэгтэй. Тэгж байж л охид хөвгүүд амьд жишээг амьдрал дээр олох болно.

Хүүхдүүдийнхээ талаарх хариуцлагаас эцэг, эхийг хэн ч чөлөөлж чадахгүй. Бид тэдэнд боловсролын болон халамжийн талаарх зөвөлгөө өгч хариуцлагаа биелүүлэхэд нь туслана.

Боловсролыг бүр эхнээс нь

Төрөхөөс нь эхлэн анхны долоо хоног, сар, жилүүд хүний амьдралд шийдвэрлэх рольтой байж болох тул эх, эцэг, эх баригчид, эмч нар, эмнэлгийн сувилагч, асрагч нар үүрэг, ажилдаа сайн бэлтгэгдсэн байх ёстой

Хүүхдийн өдөр өнжүүлэхүүд зөвхөн асран саатуулах биш, харин бас боловсрол өгөх зориулалттай. Тиймээс бид түүнийг гэр бүлүүд зөвөлгөө авч байх, цаашид сурах, өдөр бүрийн амьдралдаа найдвартай тусламж авч байх эцэг, эх, хүүхдийн төв болгох хүсэлтэй байна. Мөн тэнд хэлний дэмжлэг өгөх болон гэр бүлийн гарлаасаа болж хөгжлөөр дутмаг болсон хүүхдүүдтэй ажиллаж, бусадтай нь эн зэрэгцүүлэх зэрэг арга хэмжээ авах юм.

Социал демократууд сургуулийг төлбөрийг устгахын төлөө амжилттай тэмцсэн. Цаашид бид бүх хүүхдийг анхнаас нь үнэ төлбөргүй бүтэн өдрөөр арчлан саатуулдаг болохыг шаардаж байна. Бид одоо хүүхэд хоёр наснаасаа эхэлж сайн арчилгаа саатуулга авах эрхийг хэрэгжүүлж байгаа.

Хамтран суралцах

Манай боловсролын системд сурч боловсрох зам, боломжийг хэтэрхий эрт шийддэг. Тиймээс бид хүүхдүүд аль болох удаан хамт байж, бие биенээсээ суралцдаг сургуулийн системийг санал болгож байна. Үүнийг хэрэгжүүлэх хамгийн сайн зам бол сургуульдаа арав дугаар ангиа хүртэл хамт сурах явдал юм. Бид хамт удаан сургах сургалтын сайжруулалтыг, хүн бүрийг оноон дэмжих дэмжлэгтэй хамтруулан хэрэгжүүлэхийг хүсэж байна. Бусад орны туршлагаас үзэхэд энэ нь зөвхөн сурлага султайд нь биш, сайтайд нь ч бас тус болдог юм байна. Зөвхөн ингэж байж л боловсрох боломж нийгмийн гарлаас хамаараад байгааг таслан зогсоож болно. Германд боловсролын системд нийгмийн дорой хэсгээс гаралтай хүүхдүүд залуучуудыг дээд сургуулиа төгсгөн, их дээд сургуульд орох боломжтой болгох явдал илүү чухал болоод байна .

Сурах, нийгэмд бусадтай хамт байж хөлөө олоход суралцах газар болох бүтэн өдөр өнжүүлэх сургуулийн төлөө байна. Тэр нь хүүхэд залуучуудын хувьд гэр орноос нь гадна тэдний амьдрах бас нэг орчин болох юм. Тэгэхэд эцэг эхийн дарамт багасч, хүүхдүүд өөрийн сайн талаа нээн олж, түүнийгээ хөгжүүлнэ. Бүтэн өдөр өнжүүлэх сургууль нь үйлчилгээний байгууллагууд, биеийн тамирын

нийгэмлэгүүд, хөгжмийн сургуулиуд, ард түмний дээд сургуулиуд эсвэл залуучуудад туслах чөлөөт байгууллага ба сүмүүд гэх зэрэг бүхэл бүтэн нийгмийн орчноор хүрээлэгдсэн байдаг.

Бид сургуулиудыг биеэ даан ажиллаасай гэж хүсэж байна. Тэдэнд заавал дагах стандартуудыг өгч, түүний хангалтыг байнга шалгаж байх нь зүйтэй. Гэвч үүний хажуугаар тэд илүү ихээр өөрийн санаачлага, эрх мэдэлтэйгээр ажиллах боломжтой байх хэрэгтэй. Бидний ойлголтоор энэ нь багш нар, сурагчид, эцэг эхчүүд бүгдээрээ гаргасан шийдвэрүүдийг дагадаг, биелүүлдэг ардчилсан сургууль байх юм.

Орчин үеийн мэргэжлийн сургалт

Мэргэжлийн эхний сургалт нь цаашдын мэргэжлийн ажлын чухал эх суурийг тавьж өгдөг. Өргөн хүрээтэй эхний сургалт бүх насаараа цаашид мэргэжлээрээ сурах, ахихын урьдчилсан нөхцөл нь юм. Түүгээр барахгүй зөвхөн мэргэжлээр зогсохгүй бусад чадварыг өгдөг байх хэрэгтэй. Бүх хүүхэд залуучууд мэргэжилд суралцах эрхтэй.

Хосолсон сургалтын системийг бид цаашид хөгжүүлнэ. Ажлын ертөнцийн одоогийн түргэн хөгжилтэй алхаа нийлүүлж, шинэчлэлтийг хийж байх хэрэгтэй. Байгууллагын зардлын хувиарлалтыг зохицуулах гэх зэрэг эдийн засгийн аятай хэлбэрүүдээр сургалт явуулдаг үйлдвэр байгууллагуудыг дэмжих хэрэгтэй. Бүх залуу хүмүүсийг мэргэжлийн эхний сургалтаар сургах баталгааг бий болгохын тулд хосолсон системээр сургахад хүрэлцээ дутсан газар олон нийтийн зүгээс хариуцсан, чанар сайтай мэргэжлийн сургалтаар нөхөх хэрэгтэй. Ерөнхий боловсролыг мэргэжлийн сургалттай илүү холбож, залуу хүмүүст мэргэжлээ зөв сонгох, мэргэжлийн зүгээс тавигдах шаардлагад бэлдэх боломжийг олгох хэрэгтэй.

Үйлдвэр байгууллагууд хосолсон системд мэргэжилтнийхээ хойч үеийг сурган бэлтгэх үүргийг хүлээдэг. Тэд сургалтын төлбөрийг хамсан төлөлцөх ёстой. Бид нэмэлт ажлын байрыг бий болгоход зориулсан санхүүжилтийн моделуудыг болон өөрийн хэрэгцээнээс илүү тоогоор мэргэжилд сургаж буй үйлдвэр байгууллагуудыг дэмжих болно.

Их дээд сургуулийн сургалт ба судалгаа шинжилгээг бэхжүүлэх

Бид манай их дээд сургуулиудын сургалт, судалгаа шинжилгээг сайжруулан, суралцах оюутны тоог нэмэгдүүлнэ. Дээд сургуулиудыг төр засаг хариуцдаг, тэрээр санхүүг нь баталгаажуулах ёстой. Үүний хажуугаар холбооны улсуудын хооронд санхүүгийн тэгшитгэл хийх шаардлагатай. Хэдий тийм боловч дээд сургуулиуд аль болох биеэ даасан байдалтай байх ёстой. Дээд сургуулийн амьдралд оролцож байгаа бүх хүмүүс асуудлуудыг хамт шийдэлцдэг байх ёстой.

Сургалт, судалгаа шинжилгээ хоёр салшгүй зүйлүүд бөгөөд тэдний нэгдэл, тэдний эрх чөлөө их сургуулийн амин зүрх нь хэвээр байх ёстой. Дээд сургуулиуд сургалт, судалгаа шинжилгээний өргөн хүрээтэй программтай байх хэрэгтэй. Нийгмийн ба оюун санааны/гүн ухааны шинжлэх ухаануудыг байгалийн ба техникийн шинжлэх ухааны нэгэн адилаар дэмжих нь зүйтэй.

Их сургуулиас гадуурх судалгаа шинжилгээний байгууллагууд сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд манай шинжлэх ухааны системийн нэг чухал тулгуур болж чадсан. Бид их сургуулиас гадуурх судалгаа шинжилгээний байгууллагууд болон их дээд сургуулиудын хамтын ажиллагааг дэмжих болно.

Бид дээд сургуульд суралцахыг нээлттэй болгож, боловсролоос хол гэр бүлүүдээс гаралтай суралцагсдын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэхийг хүсэж байна. Ямар нэгэн мэргэжил эзэмшсэн хүн их дээд сургуульд сурахад санхүүгийн талаас нь боломжтой болгох хэрэгтэй. Бид эхний удаагаа их дээд сургуульд суралцахад төлбөр төлөхийг эсэргүүцэж байна. Улсын зүгээс олгодог мэргэжлийн сургалтын дэмжлэгийг хэрэгцээнд тохируулан цааш хөгжүүлэх хэрэгтэй.

Их дээд сургуульд сурах дэмжлэгийг оюутнууд олон улсын туршлагатай болоход чиглүүлэх ёстой. Үүний зэрэгцээ манай орон өөр улсуудын оюутнуудад нээлттэй байх хэрэгтэй.

Боловсролт нийгэм дэх мэргэжил дээшлүүлэлт

Бид боловсролт нийгэмдээ зориулж мэргэжил дээшлүүлэлтийг манай боловсролын системийн дөрөв дэх тулгуур болгон хөгжүүлнэ. Энэ ч бас олон нийтийн хариуцлагад байдаг. Бид цаашид суралцахыг эдийн засгийн болон ажлаас чөлөө авах эрхийн талаас нь боломжтой болгоно. Энд бид тариф зохиогчид, үйлдвэр байгууллагуудыг татан оролцуулна. Ажилтай байхыг баталгаажуулах учиртай ажилгүйдлийн даатгалыг цаашид боловсруулж, тэр нь санхүүжилтэд туслах ёстой.

Бид бас ерөнхий, соёлын ба улс төрийн цаашдын сургалтыг дэмжинэ. Энэ нь бас нас ахимаг хүмүүст ч хүртэх ёстой. Мэргэжлээ дээшлүүлснээр нас ахисан хүмүүс ажил болон нийгэмд идэвхтэй үлдэж чадна. Боловсрол нь нас ахисан хүмүүст цаг үетэйгээ хамт явах боломжийг олгодог.

Хүүхдүүд, гэр бүлийг бэхжүүлэх

Хүүхдүүд ирээдүйд итгэх итгэл, баяр хөөрийг илэрхийлдэг. Тэд аливаа нийгмийн суурь нь юм. Хүүхдүүдтэй гэр бүлүүдэд хамгийн сайн нөхцлийг бий болгосон, хүүхдүүдийн шаардлагын өмнө нээлттэй цаг ууртай нийгмийг бид хүсэж байна. Манай орны ирээдүйд тавих гол асуудлын нэг бол хүүхэд, гэр бүлийн амжилттай бодлого билээ.

Бидний зорьж байгаа зүйл бол тэтгэмж, халамжаа адил тэгш хариуцсан аав, ээж бүхий гэр бүлийн дүр зураг юм. Үүнийг залуу хүмүүсийн ихэнх нь хүсэж байна. Энэ нь хүүхдүүдэд ээж, аав нь хэрэгтэй байх хэрэгцээг тодорхойлдог ба гэр бүлийн эдийн засгийн биеэ даасан байдлыг баталгаажуулдаг.

Хүмүүс гэр бүлээсээ хайр, энэрэл, дэмжлэг, зүг чигээ олоход тус дэмийг авч чаддаг ба аюулгүй байдалд амьдарч, бие биенийхээ өмнө харилцан хариуцлага хүлээхийг сурдаг. Бид хүмүүст тодорхой амьдралын хэлбэрийг тулгахгүй. Ихэнх хүмүүс гэрлэсэн байхыг хүсдэг. Гэр бүлийг нь бид хамгаална. Үүний хажуугаар бид хамтран амьдрагчид, ижил хүйстэй хамтран амьдрагчид, ганцаараа хүүхдээ өсгөж байгаа эцэг, эх зэрэг бусад амьдралын хэлбэрүүдийг дэмжинэ. Ганцаараа хүүхдээ өсгөж байгаа эцэг, эхчүүдэд бидний тусламж онцгой хэрэгтэй. Хүүхдүүдтэйгээ эсвэл ханилсан хүмүүс эсвэл хэд хэдэн үеийнхэн хамтран амьдарч байгааг гэр бүл гэдэг. Бид хүүхэдтэй гэр бүлүүдийн нөхцлийг сайжруулж, хүүхдийн өмнө нээлттэй байх, тэднийг ойлгох ойлголцлыг дээрдүүлнэ. Бид бас хэрэв хүүхдүүд өөрийнх биш бол тэднийг тээршээлгүй, өөрийнх шиг хандан, хүүхдүүдэд баяр хөөр, урам зориг авчрах уур амьсгал бий болгож байх зорилт тавина.

Бид залуу гэр бүлүүдэд хүүхэд үеийн хүсэл мөрөөдлөө биелүүлэх, мэргэжлийн хувьд хоцрогдохоос хамгаалахад нь тусална. Энэ нь ялангуяа олон хүүхэдтэй болохоор шийдсэн хүмүүст хамаарна. Гурав

буюу түүнээс дээш хүүхэдтэй болох хүсэлтэй хосууд түүнээсээ болж эдийн засгийн хохирол амсах ёсгүй. Залуу гэр бүлүүдэд эхэлж бий болохоосоо эхлээд тодорхой үе шатуудаар тусламж шаардлагатай болдог. Үүнийг бид сайн, найдвартай халамжийн саналууд, гэр бүлд тохирсон ажлын цаг, санхүүгийн тусламж зэргээр зохицуулна.

Улсын эдийн засаг ч бас гэр бүлийн өмнө хариуцлага хүлээдэг. Амьжиргааныхаа төлөө мөнгө олох хэцүү бол хүүхэдтэй болох шийдвэрийг хүндрүүлдэг. Ямар ч цагт ажиллаж болох ажилтны дүр туйлын хүсэл болох тохиолдолд гэр бүл дарамтанд орно. Эцэг, эхийн шаардлагад таарсан ажлын цаг тэр ч байтугай байгууллагад ашиг авчирна. Бид гэр бүлд ээлтэй, түүгээрээ эцэг, эхэд ажил, гэр бүлээ хослуулах, хүүхдүүдээ зарцуулах цагтай болох боломжийг олгох ажлын ертөнцийг хүсэж байна. Энэ нь байгууллагуудын ашиг сонирхолд ч бас нийцэж байгаа юм.

Хэрэв эцэг, эхүүд салбал, тэр нь хүүхдүүдийн хувьд ядуурах эрсдлийн шалтгаан болж болохгүй. Ихэвчлэж ээжүүдэд тохиолдох хүүхдээ ганцаараа өсгөх үед аливаа нэг дэмжлэггүйгээр тэдэнд ажил хийх ямар ч боломж байхгүй. Тиймээс уг дэмжих боломжууд яаралтай хэрэгтэй.

Хүүхдийн эрх зөрчигдөх үед эцэг, эхийн эрх дуусна. Хүүхдүүд өөрсний эрхтэй. Үүгээрээ тэд хүчирхий-лэлгүй хүмүүжлийн эрхтэй. Бид энэ эрхүүдийг үндсэн хуульд тусгахыг хүсэж байна. Хаана энэ эрхүүд зөрчигдөж байна, тэнд төр засаг, нийгэм түүний эсрэг арга хэмжээ авах ёстой.

Übersetzt von Alгаа Magic

München, 11.08.2011